

Агуулга

Судалгааны зорилго	
Судалгааны агуулга.....	2
НЭГ. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	3-4
ХОЁР. ОНОЛЫН ХЭСЭГ.....	5
ГУРАВ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ.....	6-29
3.1. Малтай өрх, малчдын тоо тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд.....	6-8
3.1.1 Малтай өрх, малчдын тоо	
3.1.2 Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд	
3.2. Мал тэжээвэр амьтдын тоо, бүтэц.....	9-20
3.2.1 Малын тоо, бүтэц	
3.2.2 Хувийн малын тоо	
3.2.3 Малын бүлэглэлт	
3.2.4 Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо	
3.2.5 Төл бойжилт	
3.2.6 Том малын зүй бус хорогдол	
3.2.7 Малын хэрэглээний зарлага, сүргийн бүтэц	
3.3. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж.....	20-24
3.3.1 Бэлчээрийн хүрэлцээ, малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж	
3.3.2 Шинээр гаргасан худгийн тайлан	
3.3.3 Засварласан худгийн тайлан	
3.4. Газар тариалангийн үйлдвэрлэл.....	25-26
3.5. Мал эмнэлгийн үйлчилгээ	26-27
3.6. Улс, бүсэд эзлэх байр суурь.....	28-29
ХАВСРАЛТУУД	30-37
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	38-39
МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР.....	39

Судалгааны зорилго

“Дорнод аймгийн хөдөө аж ахуй сэдэвт энэхүү судалгааны зорилго нь мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжил, малчдын амьжиргааны талаар бодлого, малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт, хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, тэжээвэр амьтад, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд болон хөдөө аж ахуйн салбарын цаашдын чиг хандлагыг тодорхойлохын зэрэгцээ манай улсын мал аж ахуйн үйлдвэрлэлд аймгийн эзлэх байр суурийг харуулсан мэдээллээр аймгийн удирдлагууд болон хэрэглэгчдийг хангах зорилготой юм.

Судалгааны агуулга:

Манай улсын эдийн засгийн гол үндэс болсон бэлчээрийн мал аж ахуйн салбар нь эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлогод гол байр суурь эзэлсэн хэвээр байна.

Мал аж ахуйн салбар нь хүн амыг мах сүү, цагаан идээ зэрэг хүнсний бүтээгдэхүүнээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах үндсэн эх булаг болохын зэрэгцээ манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод

1 тэмээ - 1.5 бод

6 хонь - 1 бод

8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь

1 адуу - 7 хонь

1 үхэр - 6 хонь

1 хонь - 1 хонь

1 ямаа - 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу- Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25
 Азарга - 12-15
 Бух - 35-45
 Хуц, ухна - 25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж

тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс - 0.45
 Таримал тэжээл - 0.35
 Даршны ургамал - 0.25
 Гар тэжээл, хужир шүү - 1.00
 Төмс ногооны хаягдал - 0.22
 Үр тарианы хаягдал - 0.90
 Лай - 0.40

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.

-Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм. Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2014 оны төлөв байдлыг нэгтгэн тусгав.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хүн ам, өрхийн мэдээллийн санг шинэчилж, мал тэжээвэр амьтдын тооллого явуулах тухай” А/483 тоот захирамжийн дагуу мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2015 оны 12 дугаар сарын 7-ноос 17-ны өдрүүдэд Дорнод аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулав.

Энэхүү танилцуулгад 2015 оны мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал эмнэлгийн арга хэмжээ, малчдын шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган оруулав.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг сүүлийн 5 жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

III.1 МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


3.1.1 Өрх, малчдын тоо, насны бүтэц

Дорнод аймагт 2014 онд нийт 22405 өрх тоологдсоны дотор малтай өрх 6124 буюу 27.3 хувийг эзэлж байна. Үүний дотор 3910 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, үүнд 7604 малчид ажиллаж байна. 2014 онд малтай өрх өмнөх оноос 213-аар, малчин өрхийн тоо 172-оор, малчдын тоо 227-оор тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээний нийт өрхийн 27.3 хувийг хувийн малтай өрх эзэлж байгаа ба энэ нь 2013 онтой харьцуулахад 0.6 пунктээр өссөн байна.

Насны бүлгээр нь авч үзвэл 35.9 хувь нь 16-34 насны, 54.4 хувь нь 35-60 насны, 9.7 хувь нь тэтгэврийн насны хүмүүс болно.

Малчин өрхийн тоог сумдаар графикаар харуулбал:



Дээрх хүснэгтээс харахад малчин өрхийн тоо өмнөх оноос хамгийн их буурсан нь Матад, Чойбалсан сумдад 4,1- 20 хувь буюу 10 - 63 өрхөөр буурч, Баян-Уул, Хэрлэн, Дашбалбар сумдад 5-7,9 хувь буюу 19-29 өрхөөр өссөн байна.

Аймгийн дүнгээр авч үзвэл 2014 онд мал бүхий өрх 3.6 хувь буюу 213-аар өсч, малчин өрхийн тоо 0.2 хувь буюу 6 өрхөөр буурчээ. Харин мал аж ахуйн салбарт үйлдвэрлэл эрхэлж байгаа 7604 малчид ажиллаж байна.

Мал бүхий өрхийн тоо Баяндун, Матад, Халхгол, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдад өмнөх оноос 2-20 өрхөөр буурч, бусад сумдад 2-34 өрхөөр өссөн байна.

Малчин өрхийн тоо өмнөх онтой харьцуулахад Булган, Дашбалбар, Хөлөнбуйр, Баян-Уул, Хэрлэн сумдад 4-29 өрхөөр нэмэгдэж, бусад сумдад 2-63 өрхөөр буурч, Баяндун, Чулуунхороот сумд өмнөх оны түвшинд байна.

хүснэгт 1


	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
							Хувь	Зөрүү
Малтай өрх	тоо	6267	6307	5819	5911	6124	103.6	213
Үүнээс: малчин өрх	тоо	4108	4075	3744	3738	3910	104.6	172
Малчдын тоо	тоо	8543	8379	7822	7377	7604	103.1	227
Үүнээс: 16-34 насны	хүн	3713	3428	3085	2839	2729	96.1	-110
35 ба 60 нас хүртэл	хүн	3701	3976	4000	3867	4140	107.1	273
Тэтгэвэрийн насны	хүн	1129	975	737	671	735	109.5	64
Насны бүтэц %	%	100	100	100	100	100	100.0	0
Үүнээс: 16-34 насны	%	43.5	40.9	39.4	38.5	35.9	93.2	-2.6
35 ба 60 нас хүртэл	%	43.3	47.5	51.2	52.4	54.4	103.8	2
Тэтгэвэрийн насны	%	13.2	11.6	9.4	9.1	9.7	106.6	0.6

2014 онд мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа малчдын тоо өмнөх оноос 3.1 хувь буюу 227-оор өссөн байна. Сумдаар авч үзвэл малчдын тоо Баяндун, Булган, Баян-Уул, Хэрлэн сумдад 9-43 малчнаар өсч, бусад сумдад 1-264 малчнаар буурсан байна.

зураг 2

насны бүтэц

■ 16-34 насны ■ 35 ба 60 нас хүртэл ■ Тэтгэвэрийн насны



Насны бүтцийг 2010 онтой харьцуулж үзэхэд 35-60 насны малчдын тоо 11.9 хувиар өсч 60-с дээш буюу тэтгэвэрийн насны малчдын тоо 34.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

3.1.2 Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлтүүд


Малчдын ахуй соёлын үзүүлэлт нь малчдын амьжиргааг илэрхийлдэг гол үзүүлэлт билээ. Манай аймгийн хувьд 2014 оны жилийн эцсийн мал тооллогоор нийт малчин өрхийн 95.1 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 79.6 хувь нь телевизортой, 39.2 хувь нь автомашинтай, 40.6 хувь нь мотоцикльтой, 10.5 хувь нь трактортай байна.

Хүснэгт 2

	Өрхийн тоо					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2010	2011	2012	2013	2014	2010	2011	2012	2013	2014
Цахилгаантай	3908	4105	3080	2998	3718	95.1	99.2	82.3	80.2	95.1
Телевизортой	3518	3061	2723	2737	3113	85.6	75.1	72.7	73.2	79.6
Автомашинтай	1075	1414	1475	1316	1536	26.2	34.7	39.4	35.2	39.2
Мотоцикльтой	1668	1874	1771	1357	1588	40.6	45.9	47.3	36.3	40.6
Трактортой	352	374	423	360	409	8.6	9.2	11.3	9.6	10.5

Нийт малчин өрхөд цахилгаан үүсгүүртэй, телевизортой, автомашинтай, мотоцикльтой малчин өрхийн эзлэх хувь

Зураг 3



2013 онтой харьцуулахад цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо 720, автомашинтай өрх 220, мотоцикльтой өрх 231, трактортой өрх 49, телевизортой өрхийн тоо 376-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Малчдын ахуй соёлын үзүүлэлт өссөн нь малчин өрхийн тоо нэмэгдсэнтэй холбоотой юм.

III.2 МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, БҮТЭЦ

3.2.1 Малын тоо, бүтэц

2014 онд өмнөх оноос нийт малын тоо 14.2 хувь буюу 173.3 мянган толгойгоор өссөнөөс тэмээ 1.7 хувь буюу 79 толгойгоор буурч, ямаа 17.7 хувь буюу 59617 толгой, адуу 9.7 хувь буюу 15605 толгой, үхэр 14.3 хувь буюу 17807 толгой, хонь 13.6 хувь буюу 80354 толгойгоор тус тус өссөн нь манай аймгийн хувьд өмнөх жилийг бодвол цас зуд бага байсантай холбоотой юм.

Нийт малын 0.3 хувийг тэмээ, 12.7 хувийг адуу, 10.2 хувийг үхэр, 48.3 хувийг хонь, 28.5 хувийг ямаа эзэлж байна.

Сэргэлэн сум хамгийн их 21533 толгой буюу өмнөх оноос 21.6 хувиар малаа өсгөсөн ба Баянтүмэн, Гурванзагал, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Хэрлэн сумд 5 төрлөөрөө малаа өсгөсөн байна.

Малын төрөл	2010	2011	2012	2013	2014	Хүснэгт 3	
						2014/2013	
						Хувь	Зөрүү
Тэмээ	5965	5557	5007	4714	4635	98.3	-79
Адуу	136299	144102	150845	160902	176507	109.7	15605
Үхэр	107844	109684	119737	124696	142503	114.3	17807
Хонь	550786	555359	584778	592993	673347	113.6	80354
Ямаа	312388	335060	346886	336838	396455	117.7	59617
Нийт малын тоо	1113282	1149762	1207253	1220143	1393447	114.2	173304

Төлөвлөгөөт эдийн засгийн жилүүдэд (1961-1990 он) дунджаар 984.2 мян толгой малтай байсан бол 2014 оны байдлаар 1393.4 мянган толгойд хүрч 409.2 мян.толгой буюу 41.6 хувиар өслөө.

Малын тоо толгой ингэж нэмэгдсэн нь таван төрлийн малын харьцаа, цаашлаад сүргийн бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан байна.

1961 онд бог мал нийт сүргийн 77.9 хувийг эзэлж байсан ба үүний дотор хонь 68.1 хувь, ямаа 9.8 хувийг эзэлж байсан бол 2014 онд бог мал 76.8 хувийг эзэлж тухайн онтой харьцуулахад бог малын хувийн жин 1.1 пунктээр буурч, хонь 58.9 хувь, ямаа 16.9 хувийг эзэлж байгаа нь ямаан сүргийн эзлэх хувийн жин 7.1 пунктээр нэмэгдэж, хонин сүргийн эзлэх хувийн жин 9.2 пунктээр буурсан нь сүүлийн жилүүдэд ноолуурын үнэ өсч байгаатай холбоотой малчид ямааг ихээр өсгөх болсон байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

Хүснэгт 4

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.5	0.5	0.4	0.4	0.3
Адуу	12.2	12.5	12.5	13.2	12.7
Үхэр	9.7	9.5	9.9	10.2	10.2
Хонь	49.5	48.3	48.4	48.6	48.3
Ямаа	28.1	29.1	28.7	27.6	28.5

1951-1990 оны 39 жилийн дунджаар манай аймагт тэмээний тоо толгой 17.9 мянгад хүрч байсан бол 1991-2014 оны дунжаар авч үзэхэд 5.9 мянган толгойд хүрч 3 дахин буурсан байна.

Доорх хүснэгтээс харахад сүүлийн 63 жилийн хугацаанд тэмээний тоо толгой дунджаар 3.9 дахин буурсан байхад ямааны тоо 4.2 дахин нэмэгджээ.

Үүний дунд бог малын 11.2 хувийг эзэлж байсан ямааны тоо 28.5 хувийг эзлэх болсон байна.

Ямааны тоо толгойн эрс өсөлт 2004 оноос эхэлж, 1998 онд 116.2 мян.толгой байсан бол 2004 онд 234.3 мян.толгой болж даруй 2 дахин нэмэгдсэн нь ноолуур үнэд орсонтой холбоотой гэж үзэж байна.

Малын жилийн дундаж тоо толгой

Хүснэгт 5


Малын төрөл	1951-1970 оны дундаж	1971-1990 оны дундаж	1991-2010 оны дундаж	2011-2014 оны дундаж	$\frac{1971-1990^*}{\% 1951-1970^*}$	$\frac{1991-2010^*}{\% 1951-1970^*}$	$\frac{2011-2014^*}{\% 1951-1970^*}$
Бүгд	958169	1013303	903047	1242651	105.8	94.2	129.7
Тэмээ	20060.1	15785.6	6876.1	4978	78.7	34.3	24.8
Адуу	98563.9	93794.4	112052.8	158089	95.2	113.7	160.4
Үхэр	113608.1	118712.7	116426.6	124155	104.5	102.5	109.3
Хонь	644939.6	731837	471333	601619	113.5	73.1	93.3
Ямаа	81013.1	53171.4	196392.4	353810	65.6	242.4	436.7

Хамгийн олон малтай Дашбалбар сум 181.9 мян.толгой буюу нийт малын 13.1 хувь хамгийн цөөн малтай Халхгол сум 40.3 мян.толгой буюу нийт малын 2.9 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт малын тоогоор Дашбалбар сум, тэмээгээр Баянтүмэн сум, адуугаар Дашбалбар сум, үхрээр Хэрлэн сум, хонь, ямаагаар Дашбалбар сум тус тус тэргүүлж байна.

Малын тоо, сумдаар

Зураг 4



Малын тоо толгойг сумдаар өмнөх онтой харьцуулахад 181.9-119.7 мянган толгой мал тоолуулсан Дашбалбар, Цагаан-Овоо, Баяндун, Сэргэлэн, Хэрлэн сумдууд эхний тавд орлоо.

3.2.2 Хувийн малтай өрх, малын тоо

Хувийн малын тоо өмнөх оноос 15.3 хувь буюу 179.7 мян.толгойгоор өссөн байна. Малын төрлөөр нь авч үзвэл тэмээ 59 толгойгоор буурч, ямаа 60.6 мян.толгойгоор, адуу 16.3 мян.толгой, үхэр 17.5 мян.толгой, хонь 85.3 мян.толгойгоор тус тус өссөн байна.

2014 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 47.7 хувийг хонь, 29.0 хувийг ямаа, 12.8 хувийг адуу, 10.2 хувийг үхэр, 0.3 хувийг тэмээ эзэлж байна.

Хүснэгт 6

Он	Малтай өрхийн тоо	Бүгд	Үүнээс					Дүнд эзлэх хувь				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2009	6715	1385957	6202	135742	120721	658448	464844	0.4	9.8	8.7	47.5	33.5
2010	6267	1071300	5841	132060	103503	523254	306642	0.5	12.3	9.7	48.8	28.6
2011	6307	1103287	5415	139847	104636	524694	328695	0.5	12.7	9.5	47.6	29.8
2012	5819	1156252	4798	146369	114451	550092	340542	0.4	12.7	9.9	47.6	29.5
2013	5911	1169807	4576	156255	120261	558173	330542	0.4	13.4	10.3	47.7	28.3
2014	6124	1349496	4517	172576	137786	643442	391175	0.3	12.8	10.2	47.7	29.0

Аймгийн хэмжээнд 6124 өрх 1349.5 мянган толгой малтай байгаа нь 2013 оныхоос 15.4 хувиар өссөн байна.

Мал бүхий 6124 өрхийг малын тоогоор нь бүлэглэвэл, 11.9 хувь буюу 728 өрх 10 хүртэл малтай, 13.6 хувь буюу 833 өрх 11-30 малтай, 8.6 хувь буюу 524 өрх 31-50 малтай, 14.4 буюу 884 өрх 51-100 малтай, 18.4 хувь буюу 1127 өрх 101-200 малтай, 21.1 хувь буюу 1295 өрх 201-500 малтай, 8.7 хувь буюу 530 өрх 501-999 малтай, 2.4 хувь буюу 144 өрх 1000-1499 хүртэл малтай өрх, 0.6 хувь буюу 37 өрх 1500-2000 малтай, 0.4 хувь буюу 22 өрх 2001-с дээш малтай өрх байна. (Хүснэгт 7)

Хүснэгтээс харахад 201-500 малтай өрх дийлэнх хувь буюу 21.1 хувийг эзэлж байна. 2014 оны байдлаар 201-500 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 1.2 пунктээр, 101-200 хүртэл малтай малтай өрхийн эзлэх хувийн жин 0.1 пунктээр, 501-999 малтай өрхийн эзлэх хувийн жин 0.9 пунктээр, 1000-1499 малтай өрхийн эзлэх хувийн жин 0.5 пунктээр, 1500-2000 малтай өрхийн эзлэх хувийн жин 0.1 пунктээр, 2001-с дээш малтай өрхийн эзлэх хувийн жин 0.1 пунктээр тус тус өссөн байна.

3.2.3 Малтай өрхийн малын бүлэглэлт

Хүснэгт 7

	Малтай өрх		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	2013	2014	2013	2014	2013	2014
ДҮН	5911	6124	100	100	1156336	1349496
10 хүртэл малтай	762	728	12.9	11.9	4089	4067
11-30	854	833	14.4	13.6	16628	16038
31-50	514	524	8.7	8.6	21078	20906
51-100	913	884	15.4	14.4	63992	65218
101-200	1079	1127	18.3	18.4	150536	162938
201-500	1174	1295	19.9	21.1	370414	411258
501-999	460	530	7.8	8.7	330042	367641
1000-1499	113	144	1.9	2.4	115998	173112
1500-2000	27	37	0.5	0.6	47050	63446
2001-ээс дээш	15	22	0.3	0.4	36509	64872

2014 оны байдлаар аймгийн хэмжээнд 6124 малтай өрх 1349.5 мянган толгой малтай байгаа нь 2013 оныхоос 14.3 хувиар өссөн байна.

Иргэдийн хувийн малын тоог бүлэглэж судалбал 2013 оныхоос 10 хүртэл малтай өрхийн тоо 4 хувиар, 11-30 малтай өрхийн тоо 2 хувиар, 51-100 малтай өрхийн тоо 3 хувиар тус тус буурч, 31-50 хүртэл малтай өрхийн тоо 2 хувиар, 101-200 хүртэл малтай өрхийн тоо 4 хувиар, 201-500 малтай өрхийн тоо 10 хувиар, 501-999 малтай өрхийн тоо 15 хувиар, 1000-1499 малтай өрхийн тоо 27 хувиар, 1500-2000 малтай өрхийн тоо 37 хувиар, 2001-с дээш малтай өрхийн тоо 47 хувиар тус тус өссөн байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо

Хүснэгт 8

Бүлэг	Мал бүхий нэг өрхөд ногдох мал, толгой		Үүнээс:				
	2013	2014	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	198	220	1	26	20	94	56
10 хүртэл	6	6	0	1	4	0	1
11+30	19	19	0	4	8	3	4
31+50	40	40	0	8	8	11	13
51+100	73	74	0	13	12	23	25
101+200	145	145	0	21	18	55	50
201+500	314	318	1	38	30	147	98
501+999	688	694	3	79	54	375	176
1000+1499	1160	1202	6	159	91	648	255
1500+2000	1689	1715	11	228	108	978	364
2001-с дээш	2910	2949	17	471	193	1655	575

Аймгийн дунджаар мал бүхий нэг өрхөд 220 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 22 толгой малаар өссөн байна. Малтай нэг өрхөд 1 тэмээ, 26 адуу, 20 үхэр, 94 хонь, 56 ямаа ногдож байна. (Хүснэгт 8)

Нэг өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 68.1 хувь нь бог мал, 31.9 хувь нь бод мал байна.

Мал бүхий өрхийн дүнд дийлэнх хувийг эзэлж байгаа 201-500 хүртэл толгой малтай өрхөд дунджаар 318 толгой, 101-200 малтай нэг өрхөд 145 толгой мал ногдож байна.

3.2.4 Хээлтэгч малын тоо

Хүснэгт 9


	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
						%	Зөрүү
Бүгд	543606	494117	537132	551097	623260	113.1	72163
Ингэ	2121	1954	1755	1804	1744	96.7	-60
Гүү	41845	43544	45391	48661	54450	111.9	5789
Үнээ	42625	44037	47463	49013	56552	115.4	7539
Эм хонь	290672	254242	279946	289610	326457	112.7	36847
Эм ямаа	166343	150340	162577	162009	184057	113.6	22048

Хээлтэгч мал нийт малын 44.7 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 38.3 хувь, адуун сүргийн 30.2 хувь, үхэр сүргийн 39.3 хувь, хонин сүргийн 48.8 хувь, ямаан сүргийн 48.1 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч мал өмнөх оноос 72163 толгой буюу 13.1 хувиар өссөн ба гүү 11.9 хувь, үнээ 15.4 хувь, эм хонь 12.7 хувь, эм ямаа 13.6 хувиар тус тус өсч, ингэ 3.3 хувиар буурсан байна.

Хээлтэгч малын тоо, толгойгоор

Зураг 5



Хээлтэгч малын тоо Гурванзагал, Матад, Халхгол, Хэрлэн сумдад өмнөх оноос 99-9388 толгойгоор буурч, бусад сумдад 168-5397 толгойгоор өссөн байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ноогдох ёстой байтал 2014 онд нэг хуцанд 56, нэг уханд 55 хээлтэгч ноогдож байгаа нь нормоос 2 дахин өндөр байна.

Харин бод малд үржлийн нормоор нэг хээлтүүлэгчид 12-45 хээлтэгч ноогдох ёстой байтал нэг бууранд 19, азарганд 7, буханд 32 хээлтэгч ноогдож байгаа нь үржлийн нормоос доогуур байна.

Хээлтүүлэгч малын тоо

Хүснэгт 10

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	14952	16222	16289	16591	18456
Буур	118	102	86	87	94
Азарга	6073	6242	6278	6624	7221
Бух	1392	1406	1381	1518	1765
Хуц	5088	5534	5601	5477	6034
Ухна	2281	2938	2943	2885	3342

Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо

Хүснэгт 11

	Үржлийн норм	2010	2011	2012	2013	2014	Дундаж
Ингэ	20-25	18	19	20	21	19	19
Гүү	12-15.	7	7	7	7	7	7
Үнээ	35-45	31	31	34	32	32	32
Эм хонь	25-30	57	46	50	53	56	52
Эм ямаа	25-30	73	51	55	56	55	58

Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироог өмнөх онтой харьцуулахад ингэ 5.0 хувиар, эм хонь 6.0 хувиар, эм ямаа 1.8 хувиар тус тус өсч, үнээ 5.9 хувиар буурч, гүү өмнөх оны түвшинд байна.

Сүүлийн 5 жилийн дунджаас харахад 2010 онд нэг хуцанд 73 эм ямаа буюу үржлийн нормоос 2.4 дахин их хээлтэгч мал ноогдож байна.

3.2.5 Төл бойжилт

Хүснэгт 12

	З АТТ			2014	Үүнээс					2014/2013	
	2011	2012	2013		з АТТТ	о АТТТ	с АТТТ	Н АТТТ	й ү АТТ	%	АТТТ
Гарсан төл	428704	429257	431600	467649	824	35885	39355	250911	140674	108.4	36049
Хорогдсон төл	5174	8788	25776	4807	30	287	293	2164	2033	18.6	-20969
Бойжсон төл	423530	420469	405824	462842	794	35598	39062	248747	138641	114.0	57018
Бойжилтын хувь	99.2	99.8	95.1	99.4	93.4	98.8	98.7	99.7	99.4	104.5	4.3


2014 оны байдлаар оны эхний эх малын 84.4 хувь буюу 465476 эх мал төллөж, гарсан төлийн 99.4 хувь буюу 462842 төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 57018 толгой буюу 14.0 хувиар өссөн байна.

Гарсан ботгоны 93.4 хувь, унаганы 98.8 хувь, тугалны 98.7 хувь, хурганы 99.7 хувь, ишигний 99.4 хувийг бойжуулсан байна.

Бойжуулсан төлийг өмнөх онтой харьцуулан сумдаар авч үзвэл Булган, Цагаан-Овоо сумдад 3184-3270 толгойгоор буурч, бусад сумдад 657-10292 толгойгоор өссөн байна.

Бойжуулсан төлийн тоо, толгойгоор

Зураг 6



Аймгийн дүнгээр бойжуулсан төлийн тоог өмнөх онтой харьцуулахад 14.0 хувь буюу 57018 толгойгоор өссөн байна.

Бойжуулсан төл

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	272880	423530	420469	405824	462842
Ботго	740	1044	824	740	794
Унага	24835	24654	26745	29922	35598
Тугал	29274	28128	30696	34428	39062
Хурга	146443	239568	236309	222422	248747
Ишиг	71588	130136	125895	118312	138641

Хүснэгт 11

Сүүлийн 10 жилийн дундажаас харахад бойжуулсан төлийн тоо 2010 онд хамгийн бага буюу 272.9 мянган төл авсан нь 2014 онтой харьцуулахад 69.6 хувиар бага байна.


Аймгийн дүнгээр 100 эхээс 84 төл бойжуулсан нь өмнөх оноос 9 төлөөр нэмэгдсэн байна. Унага, тугал, ботго 2-7 төлөөр өсч, хурга, ишиг тус бүр 7-13 төлөөр өссөн байна.

100 эхээс бойжуулсан төл

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	41	78	85	75	84
Ботго	33	49	50	42	44
Унага	60	59	61	66	72
Тугал	58	66	70	72	79
Хурга	43	82	93	79	86
Ишиг	32	78	84	72	85

Хүснэгт 12

100 эхээс бойжуулсан төл



Хүснэгт 7

3.2.6 Том малын зүй бус хорогдол

Оны эхний нийт малын 0.6 хувьтай тэнцэх 8792 толгой мал хорогдсон нь өмнөх оноос 5.4 дахин бага буюу 39079 толгойгоор бага байна.

Нийт хорогдсон малын 33.7 хувийг ямаа, 48.6 хувийг хонь, 14.4 хувийг үхэр, 3.1 хувийг адуу, 0.2 хувийг тэмээ эзэлж байна. Нийт хорогдлын 0.6 хувь буюу 306 толгой мал өвчнөөр хорогдсон байна.


Хүснэгт 13

Оноор	Бүгд	Үүнээс					Оны эхний малд эзлэх хувь				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2010	314742	169	9084	28662	150058	126769	0.1	2.9	9.1	47.7	40.3
2011	10915	29	494	925	5678	3789	0.3	4.5	8.5	52.0	34.7
2012	14162	48	954	825	5915	6420	0.3	6.7	5.8	41.8	45.3
2013	47871	88	1498	6903	23256	16126	0.2	3.1	14.4	48.6	33.7
2014	8792	55	548	873	4293	3023	0.6	6.2	9.9	48.8	34.4

Доорх графикаас харахад 2010 онд том малын хорогдол хамгийн өндөр буюу 314742 толгой мал хорогдсон нь сүүлийн 11 жилийн байдлаар хамгийн өндөр үзүүлэлт юм.

Том малын зүй бус хорогдол, оноор

Зураг 8



3.2.7 Малын хэрэглээний зарлага

2014 онд оны эхний нийт малын 19.1 хувьтай тэнцэх 232504 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос 13260 толгой буюу 5.4 хувиар буурсан байна.

Нэг малтай өрх жилд дунджаар 41 толгой малыг өөрийн болон бусдын хэрэглээнд зориулан зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага

	Хүснэгт 14				
	2010	2011	2012	2013	2014
Бүгд	228603	232802	231480	245764	232504
Тэмээ	608	654	780	737	447
Адуу	17676	17497	18141	18056	18873
Үхэр	17516	20663	19612	20579	21893
Хонь	115803	127947	123399	130345	126626
Ямаа	77000	66041	69548	76047	61665

Оны эхний малд эзлэх хувь

Бүгд	15.8	20.9	20.1	20.4	19.1
Тэмээ	9.5	11.0	14.0	14.7	9.5
Адуу	12.6	12.8	12.6	12.0	11.7
Үхэр	13.8	19.2	17.9	17.2	17.6
Хонь	16.4	23.2	22.2	22.3	21.4
Ямаа	16.3	21.1	20.8	21.9	18.3

Оны эхний тэмээний 9.5 хувь, адууны 11.7 хувь, үхрийн 17.6 хувь, хонины 21.4 хувь, ямааны 18.3 хувийг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 19.1 хувийг бод мал, 80.9 хувийг бог мал эзэлж байна.

Сүргийн бүтэц

2014 оны байдлаар нийт сүргийн 38.4 хувь буюу 535450 толгой нь төл өсвөр насны мал, 15.6 хувь буюу 216409 толгой нь нас гүйцсэн эр мал, 44.7 хувь буюу 623260 толгой нь хээлтэгч, 1.3 хувь буюу 18328 толгой нь хээлтүүлэгч мал байна.

Сүргийн бүтэц 2014 онд

Хүснэгт 15

Толгойгоор					
2014 он	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
Бүгд	1393447	535450	216409	623260	18328
Тэмээ	4635	1914	883	1744	94
Адуу	176507	83109	31779	54450	7169
Үхэр	142503	69686	14508	56552	1757
Хонь	673347	242758	98147	326457	5985
Ямаа	396455	137983	71092	184057	3323

Малын нас, хүйсээр нийт сүрэгт эзлэх хувийн жинг өмнөх онтой харьцуулж үзэхэд 2014 оны байдлаар сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь 0.7 пункт, нас гүйцсэн эр малын эзлэх хувийн жин 7.6 пунктээр нэмэгдэж, төл өсвөр насны малын хувь 8.3 пунктээр буурч, хээлтүүлэгчийн эзлэх хувийн жин өмнөх оны түвшинд байна.

Сүргийн бүтэц, хувиар

Хүснэгт 16

Хувиар					
	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
Бүгд	100.0	38.4	15.5	44.7	1.3
Тэмээ	100.0	41.3	19.1	37.6	2.0
Адуу	100.0	47.1	18.0	30.8	4.1
Үхэр	100.0	48.9	10.2	39.7	1.2
Хонь	100.0	36.1	14.6	48.5	0.9
Ямаа	100.0	34.8	17.9	46.4	0.8

	Төл, өсвөр насны мал			Нас гүйцсэн эр мал		
	2001-2003*	2013	2014	2001-2003*	2013	2014
Бүгд	36.7	36.4	38.4	17.6	17.1	15.5
Тэмээ	23.4	38.2	41.3	46.6	21.7	19.1
Адуу	37.7	46.1	47.1	28.5	19.5	18.0
Үхэр	49.2	49.1	48.9	9.5	10.4	10.2
Хонь	35.7	33.8	36.1	14.5	16.4	14.6
Ямаа	31.8	31.6	34.8	21.3	19.4	17.9

Үргэлжлэл

	Хээлтэгч			Хээлтүүлэгч		
	2001-2003*	2013	2014	2001-2003*	2013	2014
Бүгд	44.2	45.2	44.7	1.5	1.4	1.3
Тэмээ	27.6	38.3	37.6	2.4	1.8	2.0
Адуу	29.0	30.2	30.8	4.8	4.1	4.1
Үхэр	40.0	39.3	39.7	1.3	1.2	1.2
Хонь	48.9	48.8	48.5	0.9	0.9	0.9
Ямаа	45.9	48.1	46.4	1.0	0.9	0.8

*жилийн дундаж

Нас гүйцсэн эр малын өсөлт

Хүснэгт 17

	Жилийн дундаж		
	2001-2003*	2012-2014*	$\frac{2012-2014}{2001-2003}$ %
Үхэр	9512	13491	141.8
Хонь	60529	91698	151.5
Ямаа	38583	65733	170.3

Нас гүйцсэн эр малын өсөлтийг 2012-2014 оны дунджийг 2001-2003 оны дундажтай харьцуулахад үхэрт 41.8 хувь, хонинд 51.5 хувь, ямаа 70.3 хувиар тус тус өссөн байна.

Энэ хугацаанд ямааны өсөлт хамгийн их буюу 70.3 хувиар өссөн нь ноолуурын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болсон ба ноолуурын үнэ сүүлийн жилүүдэд өссөнтэй холбоотой юм.

Хэдийгээр ноолуурын үйлдвэрлэл нэмэгдэж байгаа боловч нөгөө талаар сөрөг нөлөөтэй учир нь уламжлалт сүргийн бүтцийн харьцаа алдагдаж байна.

III.3 МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖ

3.3.1 Бэлчээрийн хүрэлцээ, малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж


Малын тоог хонин толгойд шилжүүлснээр 3143.8 мянган малд хүрч өмнөх оноос 12.5 хувиар өсчээ. 100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлснээр малын тоо 33 толгой мал ногдож байгаа нь өмнөх оноос 4 толгойгоор нэмэгдсэн байна.

Өмнөх онтой харьцуулахад хонин толгойд шилжүүлсэн малын тоо 12.5 хувиар, 100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 13.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 18

	2011	2012	2013	2014	2014/2013=%	Зөрүү
Ногоон талбайн хэмжээ /миллион га/	9442894.3	9391511.4	9391511.4	9477446.0	100.9	85934.6
100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойгоор шилжүүлсэн малын тоо	2551.5	2696.3	2794.2	3143.9	103.6	349.7
100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойгоор шилжүүлсэн малын тоо	27	28	29	33	103.6	4

**100 га бэлчээрийн талбайд ногдох хонин
толгойд шилжүүлсэн малын тоо**



Бэлтгэсэн тэжээл

Хүснэгт 19

	2010	2011	2012	2013	2014	2014/2013=%
Хадлан өвс	58696.9	57027.9	55266.3	54922.4	56978.7	103.7
Гар тэжээл	3290.8	160	477.1	200.2	27.6	13.8
Төмс хүнсний ногооны хаягдал	4.5	159.3	13.7	234.6	4.4	1.9
Үр тарианы хаягдал	75.5	110	137.6	6777.6	70.3	1.0
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	26545.6	23920.5	26154.1	29588.1	25732.2	87.0

Тэжээл хангамж

	2010	2011	2012	2013	2014	2014/2013=%
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	26545.6	23920.5	26154.1	29588.1	25732.2	87.0
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн / Мянган тол/	2462.9	2551.5	2696.3	2794.2	3143.8	112.5
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	10.8	9.4	9.7	10.5	8.2	78.1

